МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 23 өдөр Дугаар 454 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, УИХ-ын 1999 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөрийн 2015-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөрийн 2015-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / О.Баяр/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-Шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

081679

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 11 сарын 23 өдрийн
457 дугаар тушаалын хавсралт

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2015-2018 он)**

| № | Үйл ажиллагаа | Хугацаа (оноор) | Хариуцах байгууллага | Хамтран оролцох байгууллага |
|---|---|---|---|---|
| | **Зорилт 1. Монголын уламжлалт анагаах ухааны төрийн бодлогыг шинэчлэн боловсруулах** | | | |
| 1.1 | Монгол Улсын Их Хурлын 1999 оны 46 дугаар тогтоол "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын хэрэгжилтэнд үнэлгээ хийх | 2015 | Хяналт-шинжилгээ,үнэлгээ, дотоод аудитын газар | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл, |
| 1.2 | Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулж хэлэлцүүлэн, холбогдох байгууллагад хүргүүлэх | 2015-2016 | Стратегийн бодлого төлөвлөлтийн газар | Монгол уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл,<br>Аймаг, нийслэлийн ЭМГ |
| | **Зорилт 2. Хууль эрх зүйн орчны хэрэгжилтийг сайжруулах** | | | |
| 2.1 | Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх асуудлыг нэгдсэн мэргэжил, арга зүйгээр хангах асуудлыг шийдвэрлэх | 2015-2016 | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл, Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага | Эрүүл мэнд, спортын яам |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.2 | Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэхэд гадаадын зээл, тусламжийг татах, чиглүүлэхэд анхааран ажиллах | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Нийслэл, аймгийн Засаг дарга, Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |
| 2.3 | Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай зүй зохистой зэрэгцүүлэн хөгжүүлэх онол арга зүйн үндэслэлийг боловсруулах | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл, | Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |
| 2.4 | ЭМСЯ, аймаг, нийслэлийн ЭМГ-ын бүтцэд Монголын уламжлалт анагаах ухааны асуудал хариуцсан мэргэжилтнийг орон тоогоор ажиллуулах | 2015-2018 | Стратегийн бодлого төлөвлөлтийн газар | Аймаг, нийслэлийн ЭМГ |
| 2.5 | Аймагт Монголын уламжлалт анагаах ухааны төвийн тоог нэмэгдүүлэх, дүрмийг нь батлуулах | 2015-2016 | Төрийн захиргаа удирдлагын газар, Стратегийн бодлого төлөвлөлтийн газар | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл,<br>Аймгийн ЭМГ |
| 2.6 | "Монголын уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ын төслийг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулах | 2015 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 2.7 | Эрүүл мэндийг хамгаалах технологи "Уламжлалт анагаахын ор бүхий эмнэлэг, амбулаторын бүтэц, үйл ажиллагаа" MNS5700:2006 стандартыг шинэчлэн боловсруулах | 2016 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |
| 2.8 | Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр мөрдөгдөж буй оношилгоо, эмчилгээ, үйлдлийн стандартын хүртээмж, хэрэглээний байдалд үнэлгээ хийх | 2016 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар | Эрүүл мэндийн бодлогын хэрэжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 2.9 | Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж, зааврын жагсаалт | 2016-2017 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, | Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тэдгээрийг шинэчлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх | | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | |
| 2.10 | Өвчний оношийг Монголын уламжлалт анагаах ухааны өвчний ангиллын дагуу монгол хэл дээр бичих зааврыг боловсруулж, батлуулах | 2015-2016 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |
| 2.11 | Монголын уламжлалт анагаах ухааны өвчний ангилал, шинээр боловсруулсан оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, зааврыг танилцуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | 2017-2018 | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |
| **Зорилт 3. Монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалт болон давтан сургах үйл ажиллагааг сайжруулах** | | | | |
| 3.1 | Монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг төрөөс боловсролын талаар баримтлах бодлоготой уялдуулах | 2015-2017 | Стратегийн бодлого төлөвлөлтийн газар,<br>Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл,<br>Монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль |
| 3.2 | Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургууль, байгууллагын төгсөлтийн өмнөх, дараах сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, дүгнэлтэд үндэслэн сайжруулах арга хэмжээг авах | 2016-2017 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв | Монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль |
| 3.3 | Монголын уламжлалт анаагаах ухааны чиглэлээр эмч, мэргэжилтэнг гадаадын улс, оронд сургах, харилцан туршлага | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | солилцуулах ажлыг дэмжих | | хөгжлийн төв | Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |
| 3.4 | Монголын уламжлалт анагаах ухааны төгсөлтийн дараах сургалтын чиглэлийг шинэчлэх | 2016-2017 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 3.5 | Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр эмч, мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, мэргэжлийн зэрэг олгох шалгалтын тест болон гарын авлагыг шинэчлэн боловсруулах | 2015-2018 | Эрүүл мэндийн хөгжлийн төв | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 3.6 | Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр сурах бичиг, ном, гарын авлагыг боловсруулах ажлыг өргөжүүлэх | 2015-2018 | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |
| **Зорилт 4. Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх** | | | | |
| 4.1 | Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний хүчин чадлын судалгааг гаргах | 2016 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | Аймаг, нийслэлийн ЭМГ<br>Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага |
| 4.2 | Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээтэй холбоотой статистикийн мэдээний санг өргөжүүлэх | 2015-2018 | Эрүүл мэндийн хөгжлийн төв | Нийслэл, аймгийн ЭМГ, Монголын уламжлалт, анагхаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 4.3 | Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэгч нарыг чадавхийг бэхжүүлэх | 2016-2018 | Эрүүл мэндийн хөгжлийн төв | Нийслэл, аймгийн ЭМГ<br>Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 4.4 | Монголын уламжлалт анагаах ухааны | 2015-2016 | Эрүүл мэндийн хөгжлийн төв, | Аймаг, нийслэлийн ЭМГ, Монголын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | өвчний ангиллын кодыг эмнэл зүйд ашиглах талаар сургалт зохион байгуулах | | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 4.5 | Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний үйлдлийн өртөг зардлын судалгаа хийж, Монголын уламжлалт анагаах ухааны оношийн кодын дагуу ЭМДС-аас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх | 2015-2016 | Эрүүл мэнд, спортын яам, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн даатгалын газар |
| 4.6 | Монголын уламжлалт анагаах ухааны онолд суурилсан эрүүл аж төрөх зайн үйлийг хэвшүүлэх ажлыг өргөжүүлэх | 2015-2016 | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Нийслэл, аймгийн ЭМГ, Монголын уламжлалт анагаахын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага |
| 4.7 | Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, судалгаа, шинжилгээний лабораторийн, эм үйлдвэрлэлийн багаж,тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх | 2015-2018 | Стратегийн бодлого төлөвлөлтийн газар, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | Аймаг, нийслэлийн ЭМГ Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага |
| 4.8 | Монголын уламжлалт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх | 2015-2018 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв | Аймаг, нийслэлийн ЭМГ Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага |
| **Зорилт 5. Монголын уламжлалт анагаах ухааны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх** | | | | |
| 5.1 | Монголын уламжлалт анагаах ухааны эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулах, түүний дагуу судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх | 2015-2018 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Аймаг, нийслэлийн ЭМГ Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |
| 5.2 | Монголын уламжлалт анагаах ухааны өв сан, ном судар,эд зүйлсийг цуглуулах, | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Монголын уламжлалт, | Аймаг, нийслэлийн ЭМГ Монголын уламжлалт анагаах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамгаалах, хадгалах, судлах ажлыг тогтмол хийж, ховор ном судрыг орчуулж нийтийн хүртээл болгох | | анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |
| **Зорилт 6. Монголын уламжлалт анагаах ухааны эмийн үйлдвэрлэлийн технологи стандартыг боловсронгуй болгох** | | | | |
| 6.1 | "Монголын уламжлалт эмийн үйлдвэрлэлд тавигдах шаардлага" стандартыг боловсруулах, батлуулах | 2015-2016 | Эрүүл мэндийн бодлогын хэрэжилтийг зохицуулах газар, Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд |
| 6.2 | ДЭМБ-ын GMP ISO2001 стандартын шаардлага хангасан Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүдийг барьж байгуулахыг дэмжих | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд |
| 6.3 | Монголын уламжлалт эмийн фармакопейг боловсруулж мөрдөх | 2016-2018 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Фармакопейн хороо Эрүүл мэндийн хөгжлийн төв, Уламжлалт анагаахын технологийн хүрээлэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд |
| 6.4 | ДЭМБ-аас гаргасан ургамлын эмийн үйлдвэрлэлийн шаардлага, хөтөлбөрийг орчуулан нийтлүүлэх | 2015-2016 | Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| 6.5 | Монголын уламжлалт эмийг улсын бүртгэлд бүртгэх ажлыг эрчимжүүлэх | 2015-2018 | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд | Эрүүл мэнд, спортын яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 6.6 | Байгалийн гаралтай аюулгүй, чанарын баталгаатай, үр нөлөөтэй шинэ брэнд эм, уламжлалт жор, биобэлдмэл, биологийн | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл, | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | идэвхт хүнсний нэмэгдэл бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоод, гадаадад сурталчилан дэлгэрүүлэх ажлыг дэмжих | | Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | |
| 6.7 | Монголын уламжлалт эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх | 2015-2018 | Эрүүл мэнд, спортын яам, Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд |
| **Зорилт 7. Нэн ховор, ховордсон эмийн ургамлыг тарималжуулах бодлогыг дэмжих** | | | | |
| 7.1 | Монгол орны эмийн ургамал, амьтны болон эрдсийн гаралтай эмчилгээний чанартай түүхий эдийн тархац, нөөцийг сэргээх, хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2015-2018 | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд | Эрүүл мэнд, спортын яам, Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл<br>Монголын уламжлалт, анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл |
| 7.2 | Эх орны ховор, ховордсон ургамал болон манай орны нөхцөлд ургуулах боломжтой ургамлын түүхий эдийг тарималжуулах, экспортыг нэмэгдүүлэх | 2016-2018 | Монголын уламжлалт эмийн үйлдвэрүүд | Эрүүл мэнд, спортын яам, Монголын уламжлалт анагаах ухааны төр, хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургууль |